



МОНГОЛ УЛСЫН 2020 ОНЫ БАТЛАГДСАН ТӨСӨВ, ТӨСВИЙН ТОДОТГОЛ, 2021 ОНЫ ТӨСВИЙН ТӨСЛИЙН ШИНЖИЛГЭЭ

ХУРААНГУЙ

2020 оны 10 сар

УДИРТГАЛ

Монгол Улсын төсвийн орлогыг өөдрөгөөр төсөөлж, батлуулдаг нь олон жил дамжсан төсвийн алдагдал болон улсын өрийг нэмэгдүүлж, улмаар эдийн засгийн тогтворгүй байдалд хүргэх хүчин зүйл болж байгааг олон улсын донор байгууллагууд болон судлаачид дүгнэн ажил хэрэгч шүүмж, бодлогын зөвлөмжүүд санал болгосоор ирсэн. Эдгээр санал зөвлөмжийг хүлээн авч төсвийн төсөл хийхэд макро эдийн засгийн талаас төсвийн төсөл хэр бодитой болсныг ирэх жилүүдийн гадаад, дотоод эдийн засгийн төлөвтэй нь уялдуулж шинжлэх хараат бус, хөндлөнгийн судалгаа цогц хэмжээгээр хийгдэхгүй байна. Энэ хэрээр хяналт суларч, улмаар төсвийн төсөл сайжрахгүй байгаагийн нэг угтвар нөхцөл нь гэж үзэхээр байгаа юм.

2020 оны нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлогыг 11.8 их наяд, зардлыг 13.9 их наяд төгрөг байхаар тус тус баталсан (Засгийн Газар, 2019 он). Уг төсвийг баталснаас хойш эдийн засгийн нөхцөл байдал ихээхэн өөрчлөгдлөө. Дэлхий нийтийг хамарсан цар тахлын улмаас хөл хорио тогтоож, хил хааснаар төсөөлж байгаагүй эдийн засгийн онцгой нөхцөл байдал үүсэв. Үүнтэй холбоотойгоор энэ оны эхний хагас жилд эдийн засгийн өсөлт -9.7 хувь (өмнөх оны мөн үетэй харьцуулахад)-д хүрч 90-ээд оны шилжилтийн үеэс хойших эдийн засгийн хамгийн огцом уналт болов.

Энэ нь цаашлаад төсвийн орлого төлөвлөснөөс тасрах, төлөвлөгдөөгүй зардлыг нэмэгдүүлэхэд хүргэлээ.


Үүссэн нөхцөл байдалтай уялдуулж энэ оны 8 дугаар сард 2020 оны төсөвт тодотгол хийв. Үүний дараа 2021 оны төсвийн төслийг 2020 оны 10 дугаар сарын 1-нд өргөн бариад байгаа билээ. 2020 оны төсвийн хүрээний мэдэгдэл (тодотгол), 2021 оны төсвийн төсөөлөлд 2020 онд төсвийн зардлыг 700 тэрбум төгрөгөөр нэмж, алдагдлыг дотоодын нийт бүтээгдэхүүн(ДНБ)-ий 12.5 хувьд хүргэхээр, 2021 оны төсвийн зардлыг тус оноос 4.3 хувиар бууруулж, алдагдлыг 5.1 хувьд барихаар тусгажээ.

Бидний хийсэн энэхүү төсвийн шинжилгээний хүрээнд 2020 болон 2021 онуудын төсвийн баримт бичиг, тооцооллуудад шинжилгээ хийж, цаашлаад эдгээр оны төсвийн төсөөллийг эдийн засгийн бусад үзүүлэлттэй нийцүүлэн боловсруулсан болно. Эхлээд 2019 онд батлагдсан 2020 оны төсөв, түүнд 2020 онд хийсэн тодотголыг авч үзэв. Мөн 2021 оны төсвийн төслийн талаар товч тайлбар, дүгнэлтүүд өглөө. Үүний дараагаар 2020, 2021 онуудын төсвийн төсөөллийг шинээр тооцооноо танилцуулах ба эдгээр оны төсвийн төлөвлөгөө тасалдах эрсдэл байгаа эсэхийг шинжилснээ мөн тоймлон харуулав.

1. 2020 ОНЫ ТӨСӨВ

Монгол Улсын 2020 оны нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлогыг 11.8 их наяд төгрөг (өмнөх оны төлөвлөгөөнөөс 21.9 хувь, гүйцэтгэлээс 9.2 хувиар өндөр), нийт зардлыг 13.9 их наяд төгрөг (өмнөх оны төлөвлөгөөнөөс 19.7 хувиар, гүйцэтгэлээс 21.4 хувиар өндөр) байхаар баталсан билээ. Мөн төсвийн алдагдлыг ДНБ-ий 5.1 хувьд барихаар тусгажээ.

ЗУРАГ 1. 2020 ОНЫ БАТЛАГДСАН ТӨСВИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД



2020 ОНЫ ТӨСВИЙН ОРЛОГО

Гааль/хилийн боомтууд дахь сайжруулсан байгууламжийн ачаар аж ахуйн нэгжийн орлогын албан татвар (ААНОАТ), нэмэгдсэн өртгийн албан татвар (НӨАТ)-ын хураамжийг сайжруулах замаар 2020 оны баталсан төсөвт Засгийн газрын орлого 16.6 хувийн өсөлттэй байхаар тооцсон (ДНБ-ий 31.7 хувьд хүргэх) боловч эдгээр орлогын урьдчилсан тооцоо нь нэлээд өөдрөг хандлагатай байсан.

Дэлхийн банкны судалгаанд Татварын тухай багц хуулийн шинэчилсэн найруулга орлогод хэрхэн нөлөөлөхийг Засгийн газар хэтрүүлэн тооцсон гэж дурджээ¹. Тодруулбал, ААНОАТ-ыг 1.9 их наяд төгрөг буюу өмнөх оны төлөвлөгөөнөөс 28.3 хувиар өндөр байхаар баталжээ. 2020 онд уул уурхайн бүтээгдэхүүний үнэ буурна гэсэн хүлээлт байсан, мөн түүнчлэн 2019 оны ААНОАТ-ын 50 гаруй хувийг уул уурхайн салбарын компаниуд бүрдүүлж байсныг харвал татварын орлогыг хэтрүүлэн тооцоолсон байж болзошгүй харагдаж байна.

2020 ОНЫ ТӨСВИЙН ЗАРЛАГА

Төсвийн зардлын хувьд 2020 оны төсвийн төлөвлөгөө нь 2019 оны төлөвлөгөөтэй харьцуулахад 19.7 хувиар өндөр, ДНБ-ий 34.1 хувьд хүрэхээр байсан. Зардлын өсөлтийн томоохон эх үүсвэрүүд нь нийгмийн халамж, тэтгэвэр (цалин тэтгэвэр, тэтгэмжийг инфляцтай уялдуулж нэмэгдүүлэх), хөрөнгө оруулалтын зардал (ихэвчлэн хэрэгжиж буй хөрөнгө оруулалтууд), цалин хөлс ба бараа үйлчилгээний зардал (сонгуулийн зардал, агаарын бохирдлыг бууруулах зэрэг)-ууд байсан.

¹ Дэлхийн банк (2020). Уул уурхай ба оюун ухаан, Эдийн засгийн хөгжлийн загварын тойм судалгаа

2. 2020 ОНЫ ТӨСВИЙН ТОДОТГОЛ

2020 оны 1 дүгээр сарын сүүлээс Ковид-19 цар тахал эхэлж, улмаар энэ нь эдийн засагт сөрөг нөлөө үзүүлэн 2020 оны эхний хагас жилийн байдлаар Монгол Улсын эдийн засаг 9.7 хувиар хумигджээ. Үүний нөлөөгөөр төсвийн орлого буурч Засгийн газраас уг цар тахлын эсрэг авч хэрэгжүүлсэн татвар, шимтгэлийн хөнгөлөлт, халамжийг нэмсэн зэрэг 1.9 их наяд төгрөгийн бодлогын арга хэмжээнүүд нь улсын төсвийн алдагдлыг нэмэгдүүлсэн байна. Эдийн засгийн энэхүү гэнэтийн цочролын нөлөөг тусгахаар 2020 оны 8 дугаар сард 2020 оны төсөвт тодотгол хийсэн билээ.


2019 оны эхний 6 сарын байдлаар төсвийн орлого 5.5 их наяд төгрөгт хүрч байсан бол 2020 оны эхний 6 сарын байдлаар 4.4 их наяд төгрөг болжээ. Улсын төсөвт орлого 5.6 их наяд төгрөг байхаар тусгасан нь ийнхүү төлөвлөснөөс 1.2 их наяд төгрөгөөр тасрахад хүрсэн. Үүнд:

- импортын бууралт 212.4 тэрбум;
- Ковид-19 цар тахалтай тэмцэх хууль, тогтоолын дагуу татвар, шимтгэлийн хөнгөлөлт, чөлөөлөлтийн нөлөө 352 тэрбум;
- уул уурхай, газрын тосны салбарын бууралт 647.8 тэрбум төгрөгөөр тус тус буурсан нь гол нөлөөг бүрдүүлжээ.

Ковид-19 цар тахал эдийн засагт гэнэтийн цочрол үүсгэсэн нь татварын орлогыг бууруулж, төлөвлөгдөөгүй зардлыг өсгөн төсвийн тодотгол хийх гол шалтгаан болсон гэж Засгийн газар үзэж байгаа боловч 2020 оны төсвийг хэт өөдрөгөөр харж баталсан нь үүнд тодорхой хэмжээгээр нөлөөлсөн. Тэрчлэн, сонгуулийн жилийн төсөв батлахдаа орлогыг өөдрөгөөр батлах хандлага ч нөлөөлсөн гэж үзэх талтай. Урьд өмнөх сонгуулийн жилүүдийн төсвийг харахад, 2012 онд төсвийн орлогыг 5.83 их наяд төгрөг байхаар баталсан боловч оны эцэст бодит орлого нь 4.88 их наяд төгрөгт л хүрсэн. Харин 2016 онд төсвийн орлогыг 7.01 их наяд төгрөг байхаар баталсан ч мөн л төлөвлөгөөндөө хүрч чадаагүй буюу 5.85 их наяд төгрөгийн орлоготой ажилласан.

Төсвийн тогтвортой байдлын тухай хуулиар 2020 онд тэнцвэржүүлсэн тэнцлийг ДНБ-ий 5.1 хувь байхаар заасан байдаг ч төсвийн тодотголоор ДНБ-ий 12.5 хувь байхаар баталсан. Гэхдээ тус хуулийн 8 дугаар зүйлд зааснаар тусгай шаардлагын үйлчлэлийг ДНБ өсөлтгүй байх үед түдгэлзүүлж болох тул хуульд заасан тусгай шаардлагыг нэг жилээр хойшлуулж мөрдөхөөр болжээ. 2020 оны энэхүү төсвийн тодотгол нь уг хуулийг төсвийн тусгай шаардлага түдгэлзүүлсэн тохиолдолд ямар төсвийн дүрэм баримтлах, мөн тусгай шаардлагыг түдгэлзүүлсэн тохиолдол бүрт хуульд өөрчлөлт оруулахгүй байх талаас сайжруулах шаардлагатайг харууллаа.

ЗУРАГ 2. ТӨСВИЙН ОРЛОГО, 2019, 2020 ОНЫ 1-Р ХАГАС ЖИЛ



3. 2021 ОНЫ ТӨСВИЙН ТӨСӨЛ

Нэгдсэн төсвийн 2021 оны нийт орлогыг 2020 оны батлагдсан нийт дүнгээс 2.4 их наяд төгрөг буюу 22.4 хувиар нэмэгдүүлэн 13.1 их наяд төгрөг байхаар тооцжээ. Харин нийт зарлагын тухайд 2020 онтой харьцуулахад бага зэрэг буурч байгаа боловч 2019 онтой харьцуулахад 2.3 их наяд төгрөгөөр өссөн байна.

ХҮСНЭГТ 1. 2021 ОНЫ ТӨСВИЙН ТӨСЛИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД (ТЭРБУМ ТӨГРӨГ)

	он	2019	2021	2021-	
				2019	
				төсөл	Зөрүү
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛ		11,662	13,952	2,290	
Урсгал зардал		8,229	11,012	2,783	
Цалин болон нэмэгдэл урамшуулал		2,492	2,678	187	
Бараа үйлчилгээний бусад зардал		1,509	1,762	254	
Хүү		861	1,138	277	
Татаас		299	325	26	
Урсгал шилжүүлэг		3,068	5,108	2,040	
Хөрөнгийн зардал ба цэвэр зээл		3,433	2,940	494	
Хөрөнгийн зардал		3,017	3,498	482	
Эргэж төлөгдөх цэвэр зээл		416	559	975	

2021 оны төсвийн төслийг харахад орлого бүрдэлтийн хувьд хэд хэдэн асуудал үүсэх магадлалтай байна. Үүнд:

1. Нүүрсний экспортын хэмжээнээс хамаарч уул уурхайн салбараас төсөвт төвлөрүүлэх орлого тасалдах эрсдэлтэй. Ковид-19 цар тахлын нөлөө арилж өндөр хөгжилтэй орнуудын эдийн засаг хэвийн хэмжээнд ороогүй үед 2021 онд экспортлох нүүрсний хэмжээг 2019 оны түвшнээс давуулан төсөөлжээ. Энэ нь төсвийн орлого төлөвлөснөөс тасалдах эрсдэлийг нэмэгдүүлж байна.
2. 2021 онд хүн амын орлогын албан татварын орлогыг 2019 оны түвшинтэй харьцуулбал 329

ЗУРАГ 3. ТӨСВИЙН ОРЛОГО, 2018-2021 ОН (САЛБАРААР, ИХ НАЯД ТӨГРӨГ)



тэрбум төгрөгөөр өснө гэж төсөөлжээ. Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар эдийн засгийн сэргэлттэй холбоотойгоор өсөж болох юм. Харин хувь хүний орлогын албан татвар 2019 оноос 107 тэрбум төгрөгөөр өсөхөөр төсөөлсөн нь хэт өөдрөг байж болзошгүй.

3. Импортын НӨАТ-ыг 281 тэрбум төгрөгөөр, гадаад үйл ажиллагааны орлого, голчлон импортын гаалийн татвараас бүрддэг орлогыг 145 тэрбум төгрөгөөр өснө гэж үзсэн нь цар тахлын улмаас хөрөнгө оруулалт түүнтэй холбоотой импорт ойрын хугацаанд сэргэхээргүй, хилийн хорио тавигдах эсэх нь мэдэгдэхгүй байгаа нөхцөлд мөн л эрсдэл дагуулж байна.


2021 оны төсвийн нийт зарлага 2020 оны тодотголоор батлагдсан төсөвтэй харьцуулбал 4.3 хувиар буурч байгаа боловч 2019 оны төсөвтэй харьцуулахад 19.6 хувиар буюу 2.3 их наяд төгрөгөөр өсөхөөр төсөөлжээ. Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн тусгай шаардлагын зардлын өсөлтийн хязгаарлалтыг зөвхөн өмнөх оны өсөлттэй харьцуулж тогтоож байгаа нь учир дутагдалтай байж болох юм.

2021 оны төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл нь 2,154 тэрбум төгрөгийн алдагдалтай, үүний 1,596 тэрбум төгрөгийг дотоодын зах зээлээс татах, 250 тэрбум төгрөгийг гадаад эх үүсвэрээр санхүүжүүлэхээр байна. Мөн 156 тэрбум төгрөгийг Тогтворжуулалтын сангаас санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

4. ГАДААД ЭДИЙН ЗАСГИЙН ОРЧИН

Монгол Улсын төсвийн орлогын дөрөвний нэг гаруй хувийг уул уурхайн салбарын орлого бүрдүүлдэг. Уул уурхайн салбарын экспорт нь нийт экспортын 90 гаруй хувийг эзэлдэг бөгөөд нийт экспортын 90 гаруй хувь нь БНХАУ руу хийгддэг. Иймд БНХАУ-ын эдийн засгийн төлөв, цаашлаад түүхий эдийн үнийн төлөв нь манай улсын эдийн засгийн төсөөлөл, Засгийн газрын төсвийн төлөвлөгөө, гүйцэтгэлд чухал нөлөөтэй.


ЗУРАГ 4. ТӨСВИЙН ОРЛОГЫН ГҮЙЦЭТГЭЛ



Азийн Хөгжлийн Банкнаас 2020 оны 9 дүгээр сард гаргасан Азийн хөгжлийн төлөв (АХТ) 2020 тайлангийн Шинэчилсэн төсөөлөлд БНХАУ-ын 2021 оны эдийн засгийн өсөлтийг өмнөх 4 дүгээр сарын төсөөллөөс бага зэрэг нэмэгдүүлж 7.7 хувь байна гэж үзжээ. 2020 оны хэрэглээний огцом агшилт нь буцаж хэвийн байдалд орсноор 2021 оны өсөлтийг голчлон тайлбарлаж байна. Эрсдэлийн хувьд БНХАУ, АНУ-ын худалдааны сэргөлдөөн нь гүнзгийрэх, улмаар БНХАУ-ын гадаад эрэлт, эдийн засгийн өсөлт саарах нь түүхий эдийн эрэлт, үнэд сөрөг нөлөөтэй байж болох юм.

2020, 2021 онд Монгол Улс зэс болон нүүрснээс олох орлого тус салбараас төсөвт төвлөрүүлэх орлогын 83 хувийг эзэлж байна. 2021 оны төсвийн орлогын 21 хувийг энэ хоёр бүтээгдэхүүнээс олох орлого бүрдүүлж байна. Иймд тус бүтээгдэхүүний үнийн болон хэмжээний төсөөллийг оновчтой хийх нь манай улсын төсвийн орлогын төсөөллийн бодитой байдал, цаашлаад төсвийн бодлогын тогтвортой байдалд чухал нөлөөтэй.


ЗУРАГ 5. УУЛ УУРХАЙН БҮТЭЭГДЭХҮҮНЭЭС ОЛОХ ТӨСВИЙН ОРЛОГО (ТЭРБУМ ТӨГРӨГ)




2021 оны төсвийн төсөөлөлд зэсийн үнэ, экспортын хэмжээ өснө, харин нүүрсний үнэ бага зэрэг буурах боловч хэмжээ нь өснө гэж тооцоолжээ.

ЗУРАГ 6. ТӨСВИЙН ТООЦООЛОЛД ОРСОН ЭКСПОРТЫН ГОЛ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ҮНЭ, ХЭМЖЭЭНИЙ ТӨСӨӨЛӨЛ


Зэсийн үнэ, ам.доллар/тонн




Зэсийн баяжмал, экспорт, мянган тонн



Нүүрсний үнэ, ам.доллар/тонн



Нүүрсний экспорт, сая тонн




5. ТӨСВИЙН ОРЛОГЫН ТӨСӨӨЛӨЛ

Бид энэхүү судалгааны хүрээнд 2020, 2021 оны төсвийн төсөөллийн шинэчилсэн тооцоог хийн батлагдсан төсөв, түүний тодотгол болон өргөн

барьсан төсөлтэй харьцуулж судлав. Энэхүү тооцооллоор эдийн засгийн өсөлт энэ онд -1.6 хувь, ирэх онд 7.1 хувь байна гэж гарлаа².

ЗУРАГ 7. БОДИТ ДНБ-ИЙ ӨСӨЛТИЙН ТӨСӨӨЛӨЛ, ХУВИАР



ОРЛОГЫН ТӨСӨӨЛӨЛД АШИГЛАСАН АРГАЧЛАЛ

Төсөөлөл хийхдээ татвар тооцох орлого, хөрөнгө болгоныг авч үзэх нь цаг хугацаа, хүн хүч ихээхэн шаардах тул ихэнх төсөөлөлд татвар орлогын бүлгээр нь татварын суурийг төлөөлүүлэн авч үзлээ.

Төсвийн орлогын төсөөллийг бодит үйлчилж буй татварын хувийн аргачлалыг голчлон ашиглан хийлээ. Үүнд:

- ААНОАТ болон татварын бус орлогын төсөөллийг хийхдээ нэрлэсэн ДНБ-ийг суурь болгон авсан болно.
- НӨАТ-ын төсөөллийг хийхдээ ДНБ-ий төсөөллийн импорт, хэрэглээтэй нийцтэйгээр тооцсон.
- Онцгой албан татварыг мөн хэрэглээтэй нийцтэйгээр тооцсон.
- Гадаад үйл ажиллагааны орлого хэсгийн дийлэнх нь импортын гаалийн татвар байх ба үүнийг ДНБ-ий импортын хэсэгтэй нийцтэйгээр тооцлоо.
- НДШ-ийг мөн цалин хөлсний орлогыг суурь төсөөлөл болгон НДШ-ийн өөрчлөлтийг тусгалаа.
- Татварын бус орлогыг мөн төсөвт тусгасан байдлаар нь авч үзлээ.

ОРЛОГЫН ТӨСӨӨЛЛИЙН ҮР ДҮН

Дээрх арга, аргачлалын дагуу авч үзэхэд, 2020, 2021 онуудын төсвийн төсөлд төсвийн орлогыг өөдрөгөөр төсөөлсөн байгаа нь харагдлаа. Өөдрөг төсөөллийн улмаас зарим төлөвлөсөн зардлаа санхүүжүүлж чадахгүй байх эрсдэл үүснэ. Тухайлбал, бидний хийсэн тооцооллоор 2020, 2021 онуудад төсвийн орлого 125 тэрбум болон 610 тэрбум төгрөгөөр тус тус Сангийн яамны төлөвлөснөөс тасалдаж болзошгүй гэж гарлаа.

Энэхүү төсөөлөл нь Сангийн яамны эдийн засгийн төсөөлөл, мөн экспортын түүхий эдийн хэмжээний төсөөллөөс ялгаатай тул ялгаатай үр дүнг үзүүлж байж болох юм. Тухайлбал, 2021 оны нүүрсний экспортын хэмжээг Сангийн яам 42 сая тонн гэж төсөөлсөн бол бид 38 сая тонн байхаар төсөөлсөн. Хэрэв 2021 онд Сангийн яамны авч үзсэн хэмжээгээр нүүрс экспортолж чадвал дээрх эрсдэл буурна.

² Уг тооцоолол нь 2020, 2021 оны төсвийн үзүүлэлтүүдийг тусгасан, мөн төсвийн төсөөллийг хийхдээ өсөлтийн төсөөллийг оруулж, төсвийн үзүүлэлтүүдийг шинэчилж, өсөлтийг дахин тооцоолох замаар хийгдсэн төсөөлөл юм.

ХҮСНЭГТ 2. ТӨСВИЙН ОРЛОГЫН ТӨСӨӨЛӨЛ (ТЭРБУМ ТӨГРӨГ)

	он	Бидний төсөөлөл		Бидний болон СЯ-ны төсөөллийн зөрүү	
		2020	2021	2020	2021
НИЙТ ОРЛОГО БА ТУСЛАМЖ		10,604	12,524	-125	-610
ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО		9,606	11,188	-125	-610
Татварын орлого		8,722	10,145	-125	-610
Орлогын албан татвар		2,623	2,789	30	-96
Аж ахуйн нэгжийн ОАТ		1,766	1,858	-	-24
Хувь хүний ОАТ		857	931	-	-71
Нийгмийн даатгалын шимтгэл		1,520	1,990	-	-7
Нэмэгдсэн өртгийн албан татвар		2,289	2,659	11	-145
Дотоодын барааны НӨАТ		1,183	1,270	107	0
Импортын барааны НӨАТ		1,485	1,707	-117	-207
НӨАТ-ийн буцаан олголт		-379	-317	21	63
Онцгой албан татвар		670	719	-65	-220
Импорттой холбоотой				-551	-674
Бусад				-184	-265
Гадаад үйл ажиллагааны орлого		670	793	-101	-142
Бусад		949	1,194	-	-
Татварын бус орлого		884	1,043	-	-

6. ТӨСВИЙН ЗАРЛАГЫН ТӨСӨӨЛӨЛ

2020 оны төсвийн зардлын төсөөллийг хийхдээ төсвийн тодотголоос 400 тэрбум төгрөгөөр бууруулж авч үзлээ. Учир нь 2020 онд батлагдсан хөрөнгө оруулалтын 1,654 тэрбум төгрөгийн төсөл, арга хэмжээний гүйцэтгэл 2020 оны 9 дүгээр сарын 28-ны байдлаар 52.4 хувьтай байгааг 2021 оны төсвийн төсөлд дурдсаныг харгалзан хөрөнгө оруулалтын зардлыг дээрх хэмжээгээр бууруулж тооцлоо.

2021 оны төсвийн зардлын төсөөллийг мөн 610 тэрбум төгрөгөөр бууруулж авч үзлээ. Ингэхдээ мөн хөрөнгө оруулалтын зардлыг дээрх хэмжээгээр буурууллаа. Учир нь төсвийн орлого тасрахыг өмнөх хэсэгт тооцоолж гаргасан билээ. Төсвийн хуулийн дагуу алдагдлыг 5.1 хувьд барих шаардлагатай тул Засгийн газар зардлын таналт хийнэ гэж үзлээ. Урсгал зардлын хувьд байж болох хэмнэлтийг төсвийн төсөлд тооцсон тул хөрөнгө оруулалтын зардлаас хасна гэж тооцлоо.

ХҮСНЭГТ 3. ТӨСВИЙН ЗАРЛАГЫН ТӨСӨӨЛӨЛ (ТЭРБУМ ТӨГРӨГ)


он	2020		2021	
	Бидний төсөөлөл	Бидний болон СЯ-ны төсөөллийн зөрүү	2020	2021
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛ	14,177	13,342	-400	-610
Урсгал зардал	11,151	11,012	0	0
Цалин болон нэмэгдэл урамшуулал	2,957	2,678	0	0
Бараа үйлчилгээний бусад зардал	2,001	1,762	0	0
Хүү	973	1,138	0	0
Татаас	363	325	0	0
Урсгал шилжүүлэг	4,857	5,108	0	0
Хөрөнгийн зардал ба цэвэр зээл	(487)		-3914	-2940
Хөрөнгийн зардал	3,008	2,889	-400	-610
Эргэж төлөгдөх цэвэр зээл	19	(559)	0	0

ЗАРЛАГЫН ТӨСӨӨЛӨЛ ХИЙСЭН АРГАЧЛАЛ

Улсын төсвийн зардлын төсөөллийг хийхдээ бид батлагдсан төсөв, өргөн барьсан төсвийн зардлыг эхлээд шинжилсэн бөгөөд дараа нь санхүүжүүлэх боломжийг судалсны үндсэн дээр төсвийн зардлын төсөөллийг шинэчиллээ. Төсвийн зардлыг өмнөх оны ДНБ-ий зардлын гол бүрэлдэхүүн хэсгүүдийн харьцаа үзүүлэлтийг ашиглан төсөөлөл хийж болох ч төсвийн зардал нь улс төрийн шийдвэр байдаг тул ингэж тооцоолох нь алдаатай болно. Хэдийгээр батлагдсан төсөв, төсвийн алдагдал, зардлын хязгаар нь төсөөллийн эхлэх цэг боловч төсвийн тодотголоор өөрчлөлт ордог. Иймд тухайн үеийн Засгийн газрын бодлого, төлөвлөгөө, улс төрийн шийдвэрийг харгалзан зардлын төсөөллийг хийдэг.

Бидний тооцооллоор төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл 2020 онд 4,572 тэрбум төгрөг, 2021 онд 2,154 тэрбум төгрөгийн алдагдалтай гарахаар байна. Энэ нь ДНБ-ий 11.5 хувь, 5.1 хувийг тус тус эзэлж байна.

ЗУРАГ 8. ТӨСВИЙН ОРЛОГО, ЗАРДАЛ, ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН АЛДАГДАЛ (ДНБ-Д ЭЗЛЭХ ХУВИАР)



*-Судлаачдын төсөөлөл

2020 оны тооцсон төсөөллөөр төсвийн алдагдал 275 тэрбум төгрөгөөр буурч байгаа бол 2021 онд алдагдлын хэмжээ төсвийн төсөлд заасны дагуу байхаар тооцож төсвийн зардлыг бууруулсан.

2020, 2021 оны төсвийн бодлого нь эдийн засгийн өсөлт, өрхийн амьжиргааг дэмжиж байгаа боловч дотоодын зах зээлээс нийтдээ 2.8 их наяд төгрөг татахаар байгаа нь урсгал тэнцлийн алдагдал, гадаад валютын нөөцөд дарамт болохоос гадна үүсээд байгаа зээлийн тасалдлыг гүнзгийрүүлэхэд нөлөөлж болзошгүй байна.

БОЛОВСРУУЛСАН:

Г. Бумчимэг, У.Энхсайхан ("Монголын Эдийн Засгийн Шинжилгээ Судалгааны Төв" ТББ-ын судлаачид)



НЭЭЛТТЭЙ
НИЙГЭМ
ФОРУМ

Жамьян гүний гудамж-5/1,
Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар-14240
Утас: (976) 76113207